

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Агуулга

1. Оршил.....	3
2. Төслийн товч танилцуулга.....	4
3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.....	10
4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	20
5. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт	21
6. Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт	22
7. Химийн бодис, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	22
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт.....	22
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлт.....	24
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	26
11. Дүгнэлт.....	26
12. Хавсралтууд	

Хүснэгтийн жагсаалт

<i>Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол</i>	<i>5</i>
<i>Хүснэгт 2 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт</i>	<i>13</i>
<i>Хүснэгт 3. Усанд орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт</i>	<i>16</i>
<i>Хүснэгт 4 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт</i>	<i>19</i>
<i>Хүснэгт 5 Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт</i>	<i>21</i>
<i>Хүснэгт 6 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт</i>	<i>23</i>
<i>Хүснэгт 7 Хяналт шинжилгээний хүрээнд хийгдсэн ажил болон байршил, мөрдөх стандартууд</i>	<i>24</i>
<i>Хүснэгт 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт</i>	<i>25</i>
<i>Хүснэгт 9 Менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд гарсан зардал</i>	<i></i>

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

1. ОРШИЛ

“Алтан дорнод Монгол”ХХК-иас тусгай зөвшөөрлийн талбайг 2015 онд “Бат Бродерс” ХХК шилжүүлэн авсан бол “Улз групп”ХХК нь 2017 онд “Батбродерс” ХХК-иас MV-020442 тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авсан.

Тусгай зөвшөөрлийн талбай нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд орж ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй байсан.

2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газрын 289 дүгээр тогтоолоор уг хуулийн үйлчлэлийн хүрээнээс гарч “Бат Бродерс” ХХК нь 2016 онд ашиглалтын үйл ажиллагаа явуулан 5.3кг нөөцийг олборлон улсад тушаасан.

Талбайд Байгаль орчны, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын яамнаас томилогдсон ажлын хэсэг ажиллаж усан сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг тогтоон, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйл, Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу онцгой хамгаалалтын 50м бүс татан “Олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээх үйл ажиллагааны гэрээ”-г 2019 оны 05 дугаар сарын 28ны өдөр байгуулсан.

Ордын нөөц нь онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй бөгөөд “Улз групп” ХХК нь тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авснаас хойш ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй байна. Архангай аймгийн Цэнхэр сумын Орхон багийн нутагт үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжүүд алт угаасан шар усыг алдаж Орхон голд нийлүүлсэн, байгаль орчин бохирдуулснаас уг районд байх тусгай зөвшөөрлүүдийг бүрэн цуцалсан. “Улз групп” ХХК нь уг талбайд ямар нэгэн олборлолтын үйл ажиллагаа явуулаагүй болохоо Шүүхийн байгууллагаар нотлуулан тусгай зөвшөөрлийг 2021 онд сэргээсэн.

“Улз групп” ХХК нь 2022 оноос уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа стандарт, журам, Монгол улсад мөрдөгдөж буй хуулийн дагуу эрхлэн явуулахаар “Өлийн гол-1” алтны шороон ордын ТЭЗҮ-ийн тодотголыг “Идэр Мөнх арвижих” ХХК боловсруулсан. БОННУ - ний тодотгол тайланг байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Их зос”ХХК боловсруулсан.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн талбайн MV-020442 ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй талбай нь, засаг захиргааны хувьд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт "Өлийн гол-1", нэртэй газар харьяалагдана. Томоохон хот суурин болох Улаанбаатар хот ба Хархорин сумын төв нь тусгай зөвшөөрлийн талбайгаас 540 ба 130 км-т тус тус байрлах ба хатуу хучилттай авто замаас 60 км зайд байрлана.

Топопланшет L-47-48. "Бодонтын ам" алтны шороон ордын дүүрэгт жилийн аль ч улиралд автомашинаар зорчих боломжтой юм. Тус орд нь Архангай аймгийн Цэнхэр сумын төв ба Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сумын төвөөс тус тус 60 км зайд оршино. Тусгай зөвшөөрлийн талбайн газарзүйн солбицолыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1 Талбайн булангийн цэгүүдийн газарзүйн солбилцол


№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	101	43	0.6	47	0	1.7
2	101	39	15.6	47	0	1.68
3	101	39	15.64	46	59	1.67
4	101	41	8.87	46	59	1.66
5	101	41	3.27	46	59	3.42
6	101	40	53.55	46	59	6.39
7	101	40	44.01	46	59	9.81
8	101	40	34.11	46	59	11.55
9	101	40	15.41	46	59	16.99
10	101	40	5.34	46	59	18.68
11	101	39	57.39	46	59	19.32
12	101	39	46.81	46	59	18.15
13	101	39	15.64	46	59	18.98
14	101	39	15.64	46	59	22.28
15	101	39	46.53	46	59	21.39
16	101	39	57.29	46	59	22.58
17	101	40	6.19	46	59	21.87
18	101	40	16.91	46	59	20.07
19	101	40	35.64	46	59	14.62
20	101	40	45.72	46	59	12.86
21	101	40	55.61	46	59	9.31
22	101	41	5.23	46	59	6.37
23	101	41	20.19	46	59	1.66
24	101	41	25.64	46	59	1.66
25	101	41	25.64	46	59	1.31
26	101	41	50.99	46	58	49.4

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

27	101	42	16.08	46	58	40.45
28	101	42	14.13	46	58	44.37
29	101	42	19.22	46	59	3.1
30	101	42	2.64	46	59	15.75
31	101	41	56.37	46	59	19.7
32	101	41	49.9	46	59	22.45
33	101	41	43.18	46	59	26.15
34	101	41	38.78	46	59	29.56
35	101	41	31	46	59	38.93
36	101	41	30.75	46	59	39.36
37	101	41	30.73	46	59	39.87
38	101	41	30.9	46	59	40.22
39	101	41	31.1	46	59	40.51
40	101	41	31.37	46	59	40.8
41	101	41	31.79	46	59	41.02
42	101	41	32.21	46	59	41.2
43	101	41	32.83	46	59	41.3
44	101	41	33.35	46	59	41.3
45	101	41	33.83	46	59	41.23
46	101	41	34.38	46	59	41.07
47	101	41	34.83	46	59	40.83
48	101	41	35.21	46	59	40.49
49	101	41	42.65	46	59	31.45
50	101	41	46.46	46	59	28.5
51	101	41	52.64	46	59	25.1
52	101	41	59.24	46	59	22.29
53	101	42	6	46	59	18.03
54	101	42	20.32	46	59	7.15
55	101	42	20.58	46	59	8.1
56	101	42	35.44	46	59	18.06
57	101	43	0.59	46	59	22.96
58	101	43	0.59	46	59	19.59
59	101	42	37.89	46	59	15.17
60	101	42	24.96	46	59	6.5
61	101	42	19.01	46	58	44.61
62	101	42	22.64	46	58	37.34
63	101	42	29.44	46	58	25.12
64	101	42	25.68	46	58	14.59
65	101	42	30.76	46	58	5.7
66	101	42	25.68	46	58	5.7

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

67	101	42	20.74	46	58	14.36
68	101	42	24.49	46	58	24.91
69	101	42	18.32	46	58	35.99
70	101	41	48.55	46	58	46.62
71	101	41	25.64	46	58	57.38
72	101	41	25.64	46	56	21.65
73	101	42	5.64	46	56	21.65
74	101	42	5.64	46	58	5.65
75	101	43	0.64	46	58	5.65
76	101	43	0.6	47	0	1.7



Зураг 1 Талбайн байршил

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2025 онд явагдах уулын ажил, ажиллах горим

Ажиллах горим.

2025 оны 04-р сараас эхлэн 10-р сарыг дуустал ажиллана. Уулын ажил хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна. Монгол улсын хөдөлмөрийн хуулинд заасны дагуу тооцон ажиллахаар төлөвлөв.

2025 онд явагдах уулын ажил.

2025 оны ашиглалтын нийт хугацаанд 1569.3 мян.м3 хөрс хуулж 201.63мян.м3 элс олборлож, 168,5 кг алт олборлохоор уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан байна.

Үржил шимт хөрс хуулалт.

Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3- 0.6 м-ийн зузаантайгаар бульдозероор хуулан түрж техникийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайн гадна уурхайн ирмэг дагуулан түрж овоолно. Энэ нь дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн (ашигласан) блокуудыг үржил шимт хөрсөөр шууд хучиж дараа дараагийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг хэмнэх давуу талтай юм.

Хөрс хуулалт, тээвэрлэлтийн ажил.

Алт агуулсан элсний тогтоц тэгш тогтвортой, гүн бага зэрэг дотоод овоолгоор төлөвлөх таатай нөхцөл байгаа тул шимт хөрсийг түрж үүсэх карьер дагуу овоолж, ашиглагдсан хоосон орон зайг хөрсөөр нөхөн дүүргэлт хийж дотоод овоолго хийж, нөхөн сэргээлтийн ажлыг хамт хийнэ. Ил уурхайн хөрсийг олборлосон орон зайг дүүргэх зорилгоор дотоод овоолгод байршуулна. Хөрс тээвэрлэлтийн ажилд HOWO маркийн 50 тн даацтай автосамосвал ажиллах ба тээвэрлэлтийн дундаж зай 0.5 км байна.

Элс олборлолтын ажил.

Өлийн голны алтны шороон ордын элс шаварлаг их байгаа тул угаан баяжуулахад гүн болон нам дүүргэлтийн шлюз бүхий СБ-60 маркийн угаах төхөөрөмж ажиллаж шлихийн алтыг гаргана. 2025 онд нийт хугацаанд 0.83 гр/м3 агуулгатай 201.63 мян.м3 элсийг 90.05%-ийн металл авалттайгаар баяжуулж химийн цэврээр 168.5 кг (сорьц 764) алт үйлдвэрлэнэ.

Ус хангамж

Уурхайн ашиглалтын үед цэвэр усны үндсэн хэрэглэгчид нь элс угаан баяжуулах цех, ажилчдын хотхон байна. Уурхайн усан хангамжийг ордын талбайд байрлах 241.5 мян.м3 эзлэхүүнтэй үүсмэл нуур болон шүүрэлтийн усыг хуримтлуулж хангана. Өлийн гол алтны шороон орд нь Өлийн голын хөндийн ай савд хамаарагддаг бөгөөд ордын талбайд хайгуулын ажил хийгдэх явцад гидрогеологийн судлагааг “Алтандорнод Монгол” ХХК 2005-2008 онд

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

хийж гүйцэтгэсэн байна. Тус ордын усны түвшин харьцангуй бага зузаантай (2.1-8.2 м, дундажаар 4.2 м), газар доорх усны урсцын хэмжээ, усны түвшингийн хэлбэлзэл зэргийг харгалзан желонкын аргаар тодорхойлоход ордын дундажаар шүүрлийн хэмжээ 15.7 м³/цаг байсан байна.

Засвар, техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй.

Тус уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь тоног төхөөрөмж авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд шаардлагатай зарим нэг техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах, тавьж олгох зэрэг ажлыг гүйцэтгэдэг. Тоног төхөөрөмжийн их засвар, зарим нарийн төвөгтэй эд ангийг сэргээх, бүрэн солих зэрэг ажлыг засварын дагнасан газраар буюу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн газрын засварын газраар гүйцэтгүүлдэг. Засварын газар нь дараах бүрэлдэхүүнтэй байна.

Шатах тослох материалын агуулах.

ШТМ хадгалахад зориулж 50тн-ын ган сав 3 ш, тос тосолгооны материалуудыг зориулалтын савтай нь хадгалан хэрэглэнэ. ШТМ-ын агуулахыг гал, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагын норм дүрмийн дагуу байрлуулан, зориулалтын тоноглолоор хангасан байна.

Сэлбэг материалын агуулах. Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материал хадгалахад сэлбэг материалын агуулах нь уурхайн хотхонд буюу засвар механикийн хэсгийн хажууд байна.



Зураг 2. Уурхайн хотхон

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 3. Уурхайн хотхон

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

**3. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

“Улз групп”ХХК нь байгалийн баялгийг ашиглаж, үйл ажиллагаа явуулж байгаагийн хувьд оршин буй нутгийн байгаль орчныг хамгаалахад үйл ажиллагааныхаа нэг хэсгийг чиглүүлэх үүрэгтэй.

3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Хүснэгт 2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Уурхайн тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулахын тулд ашиглагдаж байгаа тээврийн хэрэгсэлд тогтмол үзлэгт хамруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Уулын мастер, засварын мастерууд	Техник ашиглалтын паспортыг тогтмол хөтлөж 100, 250, 500, 1000 мот/цаг тутамд тээврийн хэрэгслүүдийн тос, маслыг сольж байсан. Техник тоног төхөөрөмжийн үзлэг, шалгалтыг тогтмол явуулж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж гүйцэтгэсэн.
2.	Агаарын тоосжилтыг бууруулах зорилгоор дотоод тээврийн замыг болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайг тогтмол усалж байна.	Уулын мастер, үйлдвэрийн мастерууд	Автозам ба овоолго, ажлын талбайг тогтмол усан, засаж, тэгшилж ажилласан.
3.	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах - хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.	Уурхайн удирдлага, ХАБЭАБО	Уурхайн талбай доторх замуудад нэмэлтээр хурдны хязгаарын 5, 20, 40, тэмдгүүдийг байрлуулсан.
4.	Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг тогтоох, бууруулахын тулд хяналт шинжилгээг тогтмол хэрэгжүүлнэ.		Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан агаарын шинжилгээг хийлгэсэн ба шинжилгээний дүнг хавсаргав.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 5. Зам талбайн усалгаа хийж байгаа нь



АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 6. Уурхайн талбай доторх замын тэмдэг тэмдэглэгээ



Зураг 7. Уурхайн зарим байршилд нарны эрчим хүчээр цэнэглэгддэг гадна гэрэл
байршуулсан.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



Зураг 8. Агаарын чанарын шинжилгээ авч байна.

3.2 Усан орчинд нөлөөлөх сөрөг нөлөөлөл

Усны нөөцийг хамгаалах үүднээс үйлдвэрлэлийн технологит ашиглах усны хэмжээг бага байлгах үүднээс анхаарч ажилласан. Баяжуулах буюу элстэй шороог угаахад хэрэглэж буй усны 79.9%-ийг эргүүлэн ашигладаг.

Хүснэгт 3. Усанд орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Сав газартайгаа ус ашиглах гэрээгээ байгуулан төлбөрөө төлнө	Байгууллагын удирдлага	Сав газартай байгуулсан гэрээ болон ус ашигласан төлбөр төлсөн баримтаа хавсаргав.
2.	Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох бохирдохоос сэргийлэх - Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Байгууллагын удирдлага	Ажилчдын дунд сургалтыг зохион байгуулсан.
3.	Хаягдал ус зайлуулах гэрээ болон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах	Байгууллагын удирдлага	Гэрээ байгуулан үйл ажиллагаа зөвшөөрлийн дагуу явагдаж байна.
4.	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу шинжилгээ хийлгэх	Уурхайн удирдлага	5 болон 8-р саруудын хяналт шинжээний хүрээнд дээж авч шинжилгээ хийлгэсэн.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Уурхайн хотхоны хэрэгцээнд ашиглагдсан бохир усыг хоногт 30м3 усыг цэвэршүүлэх байгууламж бариулан ашиглалтанд бүрэн оруулж ажиллаж байна. Хавсралтаар холбогдох шинжилгээ болон барьж байгуулсан техник ашиглалтын тайланг хавсаргав.



Зураг 9 Ахуйн бохир цэвэрлэх байгууламжийн сүүлчийн дамжлаганаас бохир усны дээж авч буй байдал

3.3 Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

Хүснэгт 4. Газрын хэвлийн сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Газар эзэмших гэрээгээ сумын засаг даргатай байгуулах, төлбөрөө төлөх	Байгууллагын удирдлага	Гэрээ болон төлбөр төлсөн баримтаа хавсаргав.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2.	Уурхайн хуулсан Шимт болон шимэрхэг хөрсийг алдагдахаас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, хадгалах талбайг зөв тодорхойлох, овоолгыг зөв үүсгэхэд хяналт тавих ургамалжуулах зардал , нөхөн сэргээлт, ногоон байгууламжид эргүүлэн ашиглаж буй тооцоог хянах, бүртгэл хөтлөх	Уулын мастер, үйлдвэрийн мастерууд	Шимт хөрсний ургамал бүхий өнгөн хөрсийг техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд буулгаж шимт хөрсөөр хучих ажлыг хийж гүйцэтгэсэн.
3.	Тоног төхөөрөмжийн тос масло солих газрын хөрсийг хамгаалах	ХАБЭАБО	Засварын талбайгаас өөр газарт тос масло асгарсан тохиолдол бүртгэгдээгүй
4.	Засварын газраас өөр газарт тос масло асгарсан тохиолдолд асгарсан хэсгийг саармагжуулан бохирдсон хөрсийг авч хог хаягдал руу ачуулна.	Засварын мастерууд, ХАБЭАБО	Засварын талбайгаас өөр газарт тос масло солих ажлыг хориглон түүнд ХАБЭАБО хяналт тавьж ажилласан



Зураг 10. Шимт хөрснөөс дээж авч буй

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 11. Засварын талбайн хөрснөөс дээж авч буй



Зураг 12. ШТС-ын хөрснөөс дээж авч буй

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



Зураг 13. Засварын хэсгийг төрөлжүүлэн хаяглан тухайн заасан хэсэгт засвар үйлчилгээг хийдэг

3.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хамгаалах аргууд

Хүснэгт 5. Ургамал амьтны сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Олон салаа зам гаргахгүй байна.	Уурхайн удирдлага	Өдөр тутмын ажлын зааварчилгаанд заавар өгч түүнд хяналт тавьж ажилласан. Үүний үр дүнд олон салаа зам гараагүй, технологийн замаа ашиглаж байна.
2.	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл авах, олгох, бүртгэл хөтлөх	Уулын мастер, маркшейдр	Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан давхаргадас /блок/ын хүрээнд уулын ажил явагдсан.
3.	Гал түймрийн аюулаас хамгаалж гал унтраах багаж хэрэгслийг хотхон, засварын талбайд байрлуулна.	Уурхайн удирдлага, ХАБЭАБО	Гал унтраах багаж хэрэгслийг байрлуулан түүний бүрэн бүтэн байдлыг хангаж ажилласан.
4.	Газар хөндөх зөвшөөрөл, ховор ургамал хамгаалал, нөхөн сэргээлттэй холбоотой сургалт хийх	Уурхайн удирдлага	Уурхайн ажилчдад сургалт зөвлөгөө орсон

Экологийн боловсролыг дээшлүүлэх зорилготой байгаль орчны сургалтыг нутгийн иргэд болон ажилчдад Газар чандмань ХХК-ын мэргэжилтэн зохион байгуулсан.

Хуш модны экологи, самарчдын үйл ажиллагааны ойн экосистемд үзүүлэх нөлөө, монгол орны цэвдэгт тогтолцоонд гарч болзошгүй сөрөг үр дагавар, мөн өнөөгийн ойн

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

доройтол, тулгамдсан асуудлын талаар орон нутгийн иргэд болон уурхайн ажилчдад ойлголт өгөх, мэдлэгийг нь нэмэгдүүлэх зорилгоор энэхүү аман сургалт зохион байгуулав.



Зураг 14. Сургалт зохион байгуулж байгаа нь

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

4. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн ашиглалтын ажил явагдаж байхад нөхөн сэргээлт буюу дүүргэлтийн ажлыг дотоод овоолгоор зэрэгцээ байдлаар хийдэг. Энэ нь нөхөн сэргээлтийн зардлыг багасгах болоод их хэмжээний гадаад овоолгыг үүсгэн, газрын эвдрэл үүсгэхгүй байх давуу талтай.

2025 онд 4.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөсөн. 2025 онд 6.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэсэн байна.



Зураг 15 Уурхайн хүрээнд эвдэгдсэн газрын техникийн нөхөн сэргээлт



Зураг 16 Уурхайн олборлолтын хүрээнд эвдэгдсэн газрын техникийн нөхөн сэргээлт


2025 онд 3 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн. 2025 онд 4 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж хашаажуулан, ургамалын үр цацсан. Нутгийн онцлогоос хамаарч шимт хөрс нь хайргархаг сул хөрстэй. Ирэх жилийн төлөвлөгөөнд биологийн нөхөн сэргээлтийн талбайн хэмжээнд чулуу түүх ажлыг зохион байгуулан ажиллана.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 17 Биологийн нөхөн сэргээлтийн ургамал ургасан байдал

2025 онд өмнөх жилүүдийн нөхөн сэргээсэн талбайд ургамалын ургалтыг дэмжих зорилгоор иргэдийн хүсэлтийн дагуу 26 га талбайн чулууг түүсэн.



Зураг. 18 Өмнө нөхөн сэргээсэн талбайгаас чулуу түүж буй байдал

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Архангай аймгийн Хотонт сумын нутагт байрлах улсын чанартай авто зам дагуу ойн зурвас байгуулах ажлын гэрээг Архангай аймгийн Байгаль орчны газартай байгуулан 1 га талбайд техникийн шаардлагын дагуу мод тариалж, тариалснаас хойш 3 жилийн хугацаанд арчилгаа болон нөхөн тариалтыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН



Зураг 19. Мод тариалж байгаа нь



Зураг 20. Мод тариалж байгаа нь.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2025 онд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Архангай аймгийн Хотонт сумын Хөөвөр багийн нутагт байрлах “Гичгэнийн урд булаг”, “Гичгэнийн дунд булаг”-ийн урсацын дагуу хөв цөөрөм байгуулан ажилласан.



Зураг 21. Хөв цөөрөм байгуулж байгаа нь



Зураг 22. Ус хуримтлагдсан үеийн зураг

**5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй.

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны олборлолтын явцад ямар нэгэн түүх, соёлын дурсгалт зүйл олдоогүй болно.

**7. ХИМИЙН БОДИС, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ**

2025 онд осол эрсдэлгүй ажилласан байна. Хөдөлмөр аюулгүй байдлын сургалт, өдөр тутмын зааварчилгааг ХАБЭАБО хариуцсан мэргэжилтэн өгч байгаа билээ. Мөн төсөл хэрэгжих шороон ордын ашиглалтын явцад химийн тэсэрч дэлбэрэх химийн бодис ашиглаагүй.

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйл ажиллагааны явцад гарах ахуйн хог хаягдлыг Цэнхэр сумтай гэрээ байгуулан тээвэрлүүлсэн. /Төлбөр төлсөн баримт хавсаргав/ Мөн байгальд шууд хаягдах хаягдлын хэмжээг багасгахын тулд эх үүсвэр дээр нь ялган ангилалт хийх хогийн савыг уурхайн хотхон байрлуулан, ялган ангилалт хийж, ажилчдад хог хаягдлыг хэрхэн ялган ангилах талаар сургалт зохион байгуулсан.

Ашигласан тос маслыг мэргэжлийн эрх бүхий “Хай Би Ойл”ХХК -тай гэрээ байгуулан өгч байна. Гэрээг хавсралтаар оруулав.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ
№.....
Дагалдах бичгийн дугаар:.....
/шаардлагатай тохиолдолд нэмэгт хуудас хэрэглэнэ./

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Бүртгэлийн дугаар:
Нэр: Аршико Майчинг Карлрагча ХХК

2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:
Овог нэр: Болорхүү Албан тушаалтан: Хөдөлмөрийн менежер Гарын үсэг: Болорхүү Огноо: 2025 он 09 сар 18 өдөр

3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 15-329NR Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:
Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр: Хай Би Ойл ХК

4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:

№	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилал	Савлаганы бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж/кг Эсвэл/л	Аюултай хог хаягдлын код
				Дугаар	Төрөл			
1	<u>Аршико Майчинг Карлрагча ХХК</u>						<u>12900 л</u>	
2								
3								
4								
5								
6								

5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:
Арьсанд хүрсэн тохиолдолд түлэгдэх, харьшал өгнө. Арьсанд хүрсэн тохиолдолд их хэмжээний усаар угаана. Нүдрүү орсон тохиолдолд нүд угаах шингэн эсвэл их хэмжээний усаар угаана. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэлгүй ажиллахыг хориглоно.

6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:
1. Овог нэр: П.Баатархүү Гарын үсэг: П.Баатархүү Огноо: 25 он 09 сар 18 өдөр
2. Овог нэр: Э.Мөнхбат Гарын үсэг:..... Огноо:..... сар..... өдөр

7. Үл зохихлол:

8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:
Аж ахуйн нэгжийн нэр: Хай Би Ойл ХК
Бүртгэлийн дугаар: 000080
Аюултай хог хаягдлыг хүлээн авсан: Ш.Амарсайхан
Овог нэр: Шаров Амарсайхан Албан тушаал: Менежер Гарын үсэг/тамга: Менежер Огноо: 25 он 09 сар 18 өдөр

Зураг 17. Хог хаягдал хүлээлгэн өгсөн баримт

Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон биелэлт

№	Төлөвлөгөө	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Ахуйн шингэн болон хатуу хог хаягдлын цэг засвар хийх, хатуу хог хаягдлыг доторжуулах, зарим хаягдлыг нэгдсэн журмаар сумын хог хаягдлын цэгт хаях.	Уурхайн удирдлага	
2.	Хог хаягдлын төлбөрөө төлнө.	Байгууллагын удирдлага	Төлбөр төлсөн баримтаа хавсаргав
3.	Ахуйн шингэн хаягдалд бохир усны химийн шинжилгээ хийлгэх	Орчны хяналт шинжилгээний ажилд орсон	Хаягдал усанд

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

			шинжилгээ хийлгэсэн
4.	Ахуйн хатуу хог хаягдлаа төрөлжүүлэн ялган ангилах хогийн савтай байх	Уурхайн удирдлага	Хог ангилан ялгах хогийн цэг байгуулсан
5.	Ахуйн бохир цэвэршүүлэх байгууламжийг бүрэн ажилд оруулах		Ашиглалтанд орсон
6.	Уурхайн техникүүдийн засварын цех, мөн уурхайн техникт ашигласан, сольсон тос маслыг сар бүр тусгайлсан савт хуримтлуулна. Хаягдал техникийн тос, масло хуримтлуулах /сар болгон аюултай хаягдлаа 1 удаа гэрээ хийсэн газарт нийлүүлэх зайлуулах/	Уурхайн удирдлага	Хай Би Ойл ХХК-д нийлүүлсэн

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тус оны 5 болон 8-р саруудад Байгаль орчны зөвлөх үйлчилгээний эрх бүхий “Газар чандмань”ХХК-аар хийлгүүлсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд хөрс, уснаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж мөн агаар дахь тоосжилтын хэмжээ болон дуу, чимээ зэрэг үзүүлэлтүүдийн хэмжилтийг хийсэн. 5 болон 8-р саруудад хийгдсэн хяналт шинжилгээний тайлан хавсаргав.

Хүснэгт 7. Хяналт шинжилгээний хүрээнд хийгдсэн ажил болон байршил, мөрдөх стандартууд

Хяналт шинжилгээний дээж	Хяналт шинжилгээний үзүүлэлт	Хяналт шинжилгээ явуулсан хугацаа	Хяналт шинжилгээ явуулсан байршил	Хяналт шинжилгээ хийх багаж, холбогдох стандарт
Агаар	Агаар орчны бохирдол агаар дахь тоосны агууламж, NO ₂ .	5 болон 8 сард	Уурхайн карьер, Уурхайн зам, Ажилчдын хотхон	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын чанар-хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

	SO ₂ CO ₂ -ын агууламж, дуу чимээ			MNS 6063: 2010, Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS 4585: 2016
Ус	Ажилчдын унд ахуйд ашигладаг усыг бактериологи болон ундны усны ерөнхий шаардлага, цэврийн болон бохирын нуурын усыг хүнд металлын шинжилгээнд өгөх	5 болон 8 сард	Унд ахуйн ус, цэвэр болон бохирын нуур, ахуйн хаягдал ус	Усны тухай хууль, Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6148:2010, Ундны усны, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900: 2018, Байгаль орчны аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А82/128 тоот тушаалын хавсралт. Ахуйн хаягдал ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам
Хөрс	Хөрсний агрохими, нийт азот, хөдөлгөөнт фосфор, солилцох кали, карбонат, Хүнд металл(Cr, Pb, Cd, Ni, Zn), бактери	5 болон 8 сард	шимт хөрсний овоолго, засварын газар, ШТС орчим	MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр. төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах. савлах. тгэвэрлэх. хадгалах журам MNS(ISO) 4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Уурхайн үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцаж ажиллана.

Хүснэгт № 8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон биелэлт

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Биелэлт
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Компанийн захирал Байгаль орчны мэргэжилтэн	Дотоод журам боловсруулж боловсруулж байгаль орчноор хийгдэх ажлуудыг уурхайн удирдлага бүхий ажилтнуудад хуваарилан өгсөн.
2.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ болон сумын ЗДТГ-т хүргэн өгч байх		Архангай аймгийн БОГазарт хүргүүлнэ.
3.	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих		Байгаль орчны ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулах, төлбөр төлөх ажлыг цаг алдахгүй гүйцэтгэж байсан.

11. ДҮГНЭЛТ

2025 онд Дотоод овоолгоор олборлолт явуулсан талбайнд **4.5 га**-д техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөөд **6.5 га** талбайд техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

2025 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд шимт хөрс дэвсэж олон наст ургамалын үрийг цацаж ургалтыг хянаж нийт **3 га** талбайд биологийн нөхөн сэргээлт хийхээс **4 га** талбайд хийсэн. Үр худалдан авалт тариалалт 17.1 сая төгрөг.

Хяналт шинжилгээний хөтөлбөрийг Газар чандмнь ХХК тай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу **5 болон 8-р саруудад** хийж гүйцэтгүүлсэн.

“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Архангай аймгийн Хотонт сумын нутагт улсын чанартай авто зам дагуу ойн төгөл байгуулах гэрээ байгуулан **1 га** талбайд **1000 мод** тариалж эхний **3 жилийн хугацаан дахь өсөлт**, арчилгааг хариуцан ажиллаж байна.

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд нэг сум нэг цөөрөм санаачлагад нэгдэж Архангай аймгийн Хотонт сумын Хөөвөр багийн нутагт байрлах “Гичгэнийн урд булаг”, “Гичгэнийн дунд булаг”-ийн урсацын дагуу хөв цөөрөм байгуулан ажилласан. Төсөвт өртөг 13 сая төгрөг.

Уурхайн ус ашиглах гэрээг Орхон чулуут голын сав газартай байгуулан 113.4 сая төгрөг тушаасан болно. Газар ашиглалтын гэрээний дагуу 105.8 сая төгрөг, Хог хаягдлын гэрээний 2,5 сая төгрөгийг тус тус төлж ажилласан байна. Үр тариалалт 14.6 сая.

Монгол улсын “Агаарын техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2025 стандарт тоосны агууламж РМ 10, Хүхэрлэг хий, Азотын давхар исэл зэрэг үзүүлэлт нь 24 цагийн дундаж үзүүлэлтээр үзсэн. Бидний хэмжилт хийсэн газруудад агаарын техникийн ерөнхий шаардлага стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн цэнгэг буюу дунду зэрэг эрдэсжилтгүй, зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүд нь “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018 стандартын шаардлага хангаж байна.

Ахуйн бохир, Цэвэр болон бохир нуурын уснаас дээж авч “Нарт шуун консалтинг”ХХК-ын лабораторид MNS4943:2015 стандартаар шинжлүүлсэн. Стандартаас давсан үзүүлэлт илрээгүй болно.

Тус уурхайн засварын газар, ШТС-ын газрын хөрсийг “Нарт шуун консалтинг”ХХК-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн бөгөөд хүнд металлын 6 элементийг үзүүлж хүлцэх агууламжтай харьцуулсан бөгөөд хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлт гараагүй болно.

Шимт хөрс хадгалсан талбайн шимт хөрснөөс дээж авч “Нарт шуун консалтинг”ХХК-ийн лабораторид хөрсний химийн үндсэн шинж, хөрсний механик бүрэлдэхүүнийг тодорхойлуулсан. Хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ургамалд ашиглагдах элементүүдийн хангамжийн хувьд нитрат азот (NO_3) Кочергины ангиллаар 0.16мг/100г хөрсөнд байгаа нь бага хангамжтай. Хөдөлгөөнт фосфор Мачигины ангиллаар бага хангамжтай, солилцох кали бага хангамжтай, ялзмагийн агууламж багавтар байна. Солилцох сууриудын чадвар хангалттай байгаа нь үржил шим сайн байгааг илтгэнэ. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй хүрэн хөрс байна.

Уурхайн тохижилтын ажил дуусаж ажилчдын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх тогтоомын заал, болон гадаа сагс тогтох талбайг шинээр ашиглалтанд оруулсан байна. Дотроо халуун устай угаалтуур, боловсон ариун цэврийн өрөөний шийдэл бүхий халуун усны газрыг байгуулсан бөгөөд түүнийг дагсан ахуйн бохир цэвэршүүлэх төхөөрөмжийг суурьлуулсан байна.

Харьцуулан судлах зорилгоор нөхөн сэргээсэн талбайн ойролцоох байгалийн бэлчээрт ургамлын бичиглэл судалгааг хийж гүйцэтгэсэн. Тус бэлчээрт Шинэс – Хушин ойн бүлгэмдэл тархсан байна. Бүлгэмдлийн ерөнхий тусгаг бүрхэц 77%, нийт 33 зүйл ургамал бүртгэгдсэн. Нөхөн сэргээсэн талбайг байгалийн бэлчээртэй харьцуулан үзэхэд 66 хувийн төсөөтэй байв. Талбайн хэмжээнд ургамлын тусгагын бүрхэц 77%, нийт 33 зүйл бүртгэгдсэн. нийт зүйлийн 12 хувийг модлог ургамал, 9 хувийг сөөг ургамал эзэлж байгаа бол үлдсэн хувийг өвслөг ургамал эзэлж байна. Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайд олон наст ургамлын ургалт жигд,

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСТАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

ургамлын тусгаг бүрхэц 38,1%, нөхөн сэргээлтэд ашигласан олон наст ургамлууд байгалийн ургамлаар бүрэн солигдсон. Нийт талбайн хэмжээнд 9 зүйл байгалийн ургамал бүртгэгдсэн. Талбайн хэмжээнд хөл газрын ургамлаас 1 зүйл бүртгэгдсэн.



Хүснэгт 9. Менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэхэд гарсан зардал

№	Хийгдсэн ажил	Хэмжих нэгж	Зардал .төг	Тайлбар
1	Техникийн нөхөн сэргээлт /шимт хөрс дэвсэлт	4.6 га	61,641,000	
2	Техникийн нөхөн сэргээлт /дүүргэлт	2.0 га	547,920,000	
3	Биологийн нөхөн сэргээлт	4 га	54,792,000	
4	Нөхөн сэргээлтийн үр тариалалт, хашаалалт	4 га	30,848,000	
5	Хөв цөөрөм байгуулах		13,000,000	Хөв цөөрөм далан байгуулах
6	Тэрбум мод	1000 мод	58,300,000	
7	Нөхөн сэргээлт	26 га	66,617,000	Өмнөх оны нөхөн сэргээсэн талбайн чулууг түүх
8	Ус ашигласны төлбөр	1	226,853,797	
9	Газар ашигласны төлбөр	1	105,806,958	
10	Хог хаягдалын төлбөр	1 удаа	2,500,000	
11	Хяналт шалгалтын хөтөлбөр	2 удаа	8,000,000	
12	Лабораторын шинжилгээ /хяналтын хөтөлбөр	1	1,315,700	
13	Нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө	1	33,460,000	
14	Хаягдал усны төлбөр 2024	1	2,492,604	
	Нийт		1,213,547,059	

Хавсралтууд

**АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

1. Ус ашиглах гэрээ



АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ МУ-020442 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

– 2.9.2. Загвар;
 – 2.9.3. Тоолуурн тоо;
 – 2.9.4. Суурилуулсан байгууллага, огноо;
 – 2.9.5. Баталгаажуулсан байгууллага, огноо;
 – 2.9.6. Тоолуурн заалт;

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:
 2.10.1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "Усны газар"-ын дүгнэлтээр урьдчилсан байдлаар хүдэр боловсруулахад ашиглах 241'956.00 м³ гадаргын ус ашигласны төлбөр 151'506,798.3 төгрөг, уурхайн ухлагад шүүрэн орж ирэх 100'879.80 м³ газрын доорх усыг ашигласны төлбөр 74'827,591.65 төгрөг, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглах 5'386.50м³ газрын доорх ус ашигласны төлбөр 519'406.73 төгрөгийг тус тус ногдуулсан байна.
 2.10.2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т заасны дагуу усны төлбөрийг Архангай аймгийн Төрийн сан банкны дансанд 226'853'796.68 төгрөгийг төлж барагдуулна. Усны нөөц ашигласны төлбөр төлсөн баримтын хуулга, усны нөөцийг хамгаалах нөхөн сэргээх ажлын тайлан зэргийг Орхон-Чулуут голын сав газрын захиргааны orhonchuluut@gmail.com хаягаар ирүүлднэ.
 2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох бохирдуулах бодисын хэмжээ:

- Сар бүр хаягдал усны холимог сорьц авч, Архангай аймгийн байгаль орчны шинжилгээний Итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэх, орчны хяналт шинжилгээний ажлын гэрээ байгуулах;
- Шинжилгээний дүнг сав газрын захиргааны orhonchuluut@gmail.com хаягаар тухай бүр ирүүлэх;
- Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасны дагуу хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах;
- Хаягдал ус зайлуулах зөвшөөрөл авах, гэрээ байгуулах;

Гурав. Талуудын эрх, үүрэг
 3.1 Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 18.1.4, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад
 4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
 4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.
 4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн тэмдэглэл үйлдэнэ.
 4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.
 4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.
 4.5.1 Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;
 4.5.2 Аль нэг тал татан буугдсан бол


4.6 Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийн төлөөлөгч:
 Орхон-Чулуут голын сав газрын захиргааны гадаргын усны нөөц судалгаа шинжилгээний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
 /Д.Оюунбаяр/
 Хаяг: Архангай аймаг Эрдэнэбулган сум, 3-р баг, Монгол Даатгалын байр
 Орхон-Чулуут голын сав газрын захиргааны байр.
 Харилцах утас: 95334339

Ус ашиглагчийн төлөөлөгч:
 Амрико мэйнинг ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн Э.Мөнхтуяа
 Хаяг: Архангай аймаг Эрдэнэбулган сум, 3-р баг, Монгол Даатгалын байр
 Харилцах утас: 88107628

2. Ус ашиглах дүгнэлт



УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 3 дугаар сарын 27 -ний өдөр Улаанбаатар хот
Утас: 265528, 265578

Дугаар 8-3503-000008

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Огноосон нэр: Амрико мэйнинг корпорэйц ХХК
 Улсын бүртгэлийн дугаар:
 Регистрийн дугаар: 3020886
 Зөвлөл: Мөнхсүмбэрэн
 Холбоо барих дугаар: 99090844
 Факс:
 И-мэйл хаяг:

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших Өвлийн гол-1 нэртэй МУ-020442 тусгай зөвшөөрлийн талбай
 Байршил: Архангай, Цэнхэр, 1-р баг, Орхон
 Хэрэглэгчид сав газар: Орхон голын сав газар
 Хамрагдал салбар: Уул уурхай
 Төслийн дэлгэрэнгүй: "Амрико мэйнинг корпорэйц" ХХК нь Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших Өвлийн гол-1 нэртэй МУ-020442 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг эзэмшдэг.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
 Амрико мэйнинг корпорэйц

4. Ажиллах горим, хүчин чадал

Трг ашиглах хугацаа	Ажиллах горим	Жилд ашиглах хонго	Хонгог ашиглах ажиллагаа 100	Хонгог ашиглах цаг
2	2 ээлжээр	210	171	20

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тог хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Хүдэр боловсруулахад ашиглах усны хэмжээ	201630.0	тонн	Архангай аймгийн Цэнхэр сумын Өвлийн гол-1 ордон 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний нөвцт 3-т 201.63 млн.тн хүдэр угаах бажуулахаар төлөвлөсөн байна. Усны газрын 2022 оны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд

Ажлын нэр	Тог хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Уурхайн ухлагад шүүрэн орж ирэх усны хэмжээ	480.38	м3	нөвт ус хэрэглээний 30 хувийг нөхөн салбартгаар Бодын голоос авч ашиглахаар тусгасан байна.
Зөв талбайн тоосжилт дараахь ашиглах усны хэмжээ	13400.0	м3	БОННТ-ийн 38-р хуудсанд 5.56 л/сек шүүрлийн ус орж ирэхээр тооцсон байна.
Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ	30000.0	м3	БОННТ-ийн 38-р хуудсанд 12,400.0 м3 талбайн тоосжилт дараахь төлөвлөсөн байна.
"Тэрлүү мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тасьсан болон, тархаар төлөвлөсөн модны арчлалтас үсэлтэнд ашиглах усны хэмжээ	2000.0	ш	Архангай аймгийн Цэнхэр сумын Өвлийн гол-1 ордон 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний нөвцт 12-т 1,000.0 ш мод тархаар төлөвлөж, 2024 онд 1,000.0 ш мод тарьсан байна.
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	171.0	хонгог 1 хүн	Архангай аймгийн Цэнхэр сумын Өвлийн гол-1 ордон 2025 оны уулын ажлын төлөвлөгөөний нөвцт 3, 12-т 171 хүн, 210 хонгог 2 ээлжээр ашиглахаар төлөвлөсөн байна.

6. Усны эх үүсвэр, нөөц, хонгог ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөвц (л)	Усны нөвц (м3)	Тайлбар
Гадаргын ус	Технологийн хэрэгцээнд	12.0	1038.8	Усны газрын 2022.07.25-ны өдрийн 218 дугаартай Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтэд төсөл хэрэгжүүлэгчид шаардагдах ажилчдын усны 0.89 м3/хон усны хэрэгцээг шууд худалдан авалт хийж, өөрийн 10.35 м3/хон усны Бодотын голоос заавар, технологийг авч талбай, ногоон байгууламжийн усалтаны усны хэрэгцээг 1,307.54 м3/хон усны хуримтлуулсан ус (224,332.0 м3), уурхайн шүүрлийн (5.56 л/сек бууруу 80.0 м3/хон) уснаас хангаж усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг хуримтлалтай гэсэн байна. Бодотын голын дундаж урсгал нь 10-12 л/сек (884.0 - 1,036.8 м3/хон) бөгөөд урсгал 1.2 хувийг зарцуулж байна.

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААН: ИХ 400
 Холбоо барих: 88107628
 Нэмэлт мэдээлэл:

8. Усны барилга байгууламжууд

АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НУТАГТ ОРШИХ MV-020442 АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙ “ӨЛИЙН ГОЛ 1 ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Борлогч байгууламж	Хүчин мэдэл (м3)	Хэмжээ хийц
Усан сан	483540.0	"Өлийн гол-1" алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн хөгжлийн сангийн зурга төслийн 2022 онд "Нью Гидропроект" ХХК боловсруулж, батлуулсан.
Усан сан	194397.03	"Өлийн гол-1" алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн хөгжлийн сангийн зурга төслийн 2022 онд "Нью Гидропроект" ХХК боловсруулж, батлуулсан.

9. Дэмжүүлэх байгууламж

Хэмжээ (эхлэх цэг)	Хэвнэ хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дэмжүүлэх аугамын урт, м
Бодотын гол	Угав төхөөрөмж	100	500

10. Онцгой нөхцөл

- Усны тухай хуулийн 30.1.3-т заасны дагуу усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиглуулах ууртгай тул хуульд заасан үүрэг биелүүлэх үүрэгтэй байгааг анхаарч;
- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулж;
- Усны сан бүхий газрын хамгаалалтын бусад үйл ажиллагааг явуулахыг хяргилж;
- Голын хамгаалалтын бусад хэрс куулагт, олборлолт явуулахыг хяргилж;
- Тусгай зөвшөөрлийн талбайд байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, тав цагарын байгуулах, татлын ойжуулалт хийж г.м.

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Төр Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ, м3	Төлбөр тооцох усны хэмжээ, м3
Хүдэр боловсруулахад ашиглах усны хэмжээ	201630.0	тонн	4.0	1.0	Удав	806,520.00	564,564.00	241,956.00
Уурайн уулгад шуурэн орж ирэх усны хэмжээ	480.38	м3	1.0	210.0	Хөнгө	100,879.80	0.00	100,879.80
Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах усны хэмжээ	12400.0	м2	0.002	120.0	Хөнгө	2,976.00	2,976.00	0.00
Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усны хэмжээ	30500.0	м2	0.004	18.0	Удав	2,160.00	2,160.00	0.00
